

Татвараас зайлсхийх байдал дахь гадаад өрийн нөлөө: Монгол Улсын жишээн дээр

The Effect of External Debt on Tax Avoidance: Evidence from Mongolia

Э. Цэцэгдэлгэр¹

Хураангуй

Бид энэхүү судалгааны ажлаараа Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын татвараас зайлсхийх байдалд улсын гадаад өр хэрхэн нөлөөлж байгааг тодруулахыг зорьсон. Судалгааны түүвэрт 2013-2016 онуудад тасралтгүй үйл ажиллагаа явуулж санхүүгийн тайлангаа тогтмол илгээж байсан 15,571 аж ахуйн нэгж, байгууллагын 62,282 санхүүгийн тайлангийн мэдээлэл, мөн хугацааны Монгол Улсын гадаад өрийн мэдээллүүд тус тус ашиглагдсан. Тооцооллын үр дүнд улсын гадаад өрийн нийт хэмжээ, улсын болон хувийн секторын гадаад өрийн нийт хэмжээ болон урт хугацаатай өрийн хэмжээ нь аж ахуйн нэгж, байгууллагуудын татвараас зайлсхийх байдалд сөрөг нөлөөтэй бол богино хугацаатай гадаад өрийн хэмжээ эерэг нөлөөтэй болох нь тогтоогдсон. Дээрх үр дүнд салбарын нөлөөлөл байгаа эсэхийг тодруулах зорилгоор тооцооллыг давтаж үзэхэд уул уурхайгаас бусад салбарын хувьд ялгаатай байдлаар нөлөөлж буй үр дүн гарлаа.

Түлхүүр үгс: татвараас зайлсхийх байдал, татварын үр ашигтай хувь хэмжээ, улсын гадаад өр, үндэсний нийт орлого

Abstract

This study aims to investigate the effect of state external debt on tax avoidance among operating entities in Mongolia. We analyze financial statement data from 62,282 records of 15,571 unique entities, which continuously operated and submitted their statements for the consecutive years of 2013-2016. Additionally, we incorporate state external debt data for Mongolia. The estimation results reveal that total external debt, as well as both public and private sector total external debt and long-term external debt, are significantly negatively associated with tax avoidance in the sampled entities. In contrast, short-term debt is positively associated with tax avoidance. To clarify the industry effect on these results, we conduct additional tests. The findings are mixed among various sectors, with the exception of the mining industry.

Keywords: tax avoidance, effective tax rate, state external debt, gross national income

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: tsetsegdelger@num.edu.mn

Удиртгал

Татвараас зайлсхийх байдал нь төрд төвлөрөх ёстой орлогыг бууруулж, төрийн сан бүрдүүлэх болон бодлого хэрэгжүүлэх боломжийг хязгаарладаг эрсдэлтэй учраас нарийвчлан судлах асуудлуудын нэг мөн юм. Улсын төсвийн орлогын ихэнх хувийг татварын орлого бүрдүүлдэг бөгөөд хуулиар ногдуулсан албан татвараа төлөх нь иргэн бүрийн үүрэг хэмээн Монгол Улсын Үндсэн Хуулинд заасан байдаг. Тиймээс аж ахуйн нэгж, байгууллагуудын татвараас зайлсхийж буй байдлыг эдийн засгийн хэмжигдэхүүнээр илрүүлж, түүнд нөлөөлж буй микро болон макро хүчин зүйлүүдийг тооцож цаашид авах арга хэмжээг боловсруулах нь чухал (Цэцэгдэлгэр & Алтан-Эрдэнэ, 2021). Энэ чиглэлийн судалгаа одоогоор манай улсад маш бага хийгдсэн бөгөөд татвараас зайлсхийж буй байдалд улсын гадаад өр хэрхэн нөлөөлж буйг үнэлсэн ажил хараахан хийгдээгүй байгаа нь бидний уг судалгааны ажлыг хийх нэг шалтгаан болсон. Энэхүү ажлын гол зорилго бол Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын татвараас зайлсхийх байдалд улсын гадаад өр хэрхэн нөлөөлж байгааг тооцох явдал юм. Татвараас зайлсхийх байдлыг тодорхойлогч хүчин зүйлсийг судлах нь сүүлийн хорин жилийн хугацаанд нягтлан бодох бүртгэлийн салбарт чухал асуудал байсаар ирсэн шалтгаан нь татвар төлөгчид татвар ногдох орлогоо бууруулах арга замыг үргэлж эрэлхийлсээр байгаа явдал юм (Halioui нар, 2016). Онолын хувьд татвараас зайлсхийх байдлыг эрдэмтэд ялгаатай тодорхойлсон байдаг. Тухайлбал, Desai & Dharmapala (2009) нар байгууллагын татвараас зайлсхийх байдлыг алдаатай тодорхойлсон гэж

үзсэн байхад, Dyreng нар (2008) татвараас зайлсхийх байдлыг “Нягтлан бодох бүртгэлийн татварын өмнөх ашгийн нэг доллар тутамд багахан хэмжээний татвар төлөх чадвар” юм гэж тодорхойлсон байдаг. Тиймээс татвараас зайлсхийх байдлыг одоогийн хууль тогтоомжийг зөрчихгүйгээр төлөх татварын хэмжээг бууруулах оролдлого гэж дийлэнх судлаачид үздэг байна. Үүнээс гадна урт хугацаанд татвараас зайлсхийх нь компанийн хэмжээтэй эерэг хамааралтай болохыг Dyreng нар (2008), Richardson нар (2015) болон Richardson & Lanis (2007) нарын эрдэмтэд тодорхойлсон байдаг бөгөөд том компаниуд жижиг компаниудтай харьцуулахад илүү их эрх мэдэлтэй байдагтай холбон тайлбарладаг байна.

Бусад улсын хувьд татвараас зайлсхийх байдлыг компанийн болон улсын хэмжээнд судалсан онолын болон эмпирик судалгаануудын заримаас дурьдвал, Armstrong нар (2012) аж ахуйн нэгжийн татвараас зайлсхийх байдлыг хамаарах хувьсагч болгон түүнд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг шинжилсэн байдаг. Мөн Richardson нар (2015) татвараас зайлсхийх нь аж ахуйн нэгжийн өрийн бодлогод хэрхэн нөлөөлж байгаа асуудлыг судалсан. Armstrong нар (2012) татварын албаны удирдлагуудад олгосон урамшуулал нь татвараас зайлсхийх байдалтай холбоотой эсэхийг үнэлэхдээ 2002-2006 оны санхүүгийн жилийг хамарсан 423 компанийн мэдээллийг сонгон ашигласан бөгөөд судалгааны үр дүн сөрөг хамаарлыг харуулсан. Мосану нар (2021) Румын улсын 2013-2017 онуудад үйл ажиллагаа явуулж байсан компаниудын татвараас зайлсхийх хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон. Тус

судалгаанд татвараас зайлсхийсэн гэм буруутай нь тогтоогдсон 236 аж ахуйн нэгжийг хамруулсан бөгөөд компани том байх тусам татвараас зайлсхийх хандлагатай байдгийг тогтоожээ.

Манай улсын хувьд энэ чиглэлийн ажил цөөхөн байна. Цэцэгдэлгэр & Алтан-Эрдэнэ (2021) нар манай улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын татвараас зайлсхийж буй эсэхийг Dyreng (2008) нарын боловсруулсан татварын үр ашигтай хувь хэмжээний загвар (long-run cash effective tax rate-ETR) ашиглан тооцохыг зорьсон. Судалгааны үр дүн түүвэрт сонгогдсон нийт аж ахуйн нэгжүүдийн 50 орчим хувь нь тэдгээрийн хэмжээ байршил, бүс нутгийн ялгарлаас үл хамаарч богино болон урт хугацаанд татвараас тогтвортой зайлсхийж байгааг харуулсан бөгөөд түүнд микро болон макро түвшинд нөлөөлж буй үзүүлэлтүүдийн судалгаа шат дараалалтай хийгдэж байна.

Улсын гадаад өр гэдэг нь Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тодорхойлсноор: “Ямар нэгэн өгөгдсөн хугацааны эцэс дэх тухайн улсад харъяалалгүй иргэний эзэмших бодит мөнгөний хэмжээ буюу ирээдүйд үндсэн эсвэл хүүний төлбөрийг зээлдэгчдээс шаардах өр төлбөр” юм. Үүнд хувийн арилжааны банкууд, засгийн газрууд, ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын эзэмшдэг өр багтана. Монгол Улсын Засгийн газрын өрийн үлдэгдэл нь 2016 онд 22,280.1 тэрбум төгрөг байсан бол 2021 оны байдлаар 26,912.7 тэрбум төгрөг болон 20.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Catao нар (2014) цэвэр гадаад позиц болон дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааны дээд хязгаарыг -49 хувь байх нь зохистой гэж тодорхойлсон байдаг. Гэвч уг харьцаа

нь манай улсын хувьд -260 хувь байна. Мөн нийт гадаад өр болон дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааны дээд хязгаар 35 хувь байвал зохистой гэж үздэг бол манай улсын хувьд уг харьцаа 220 хувь байгаа нь улсын эдийн засаг төдий чинээ муу байгааг харуулж байна. Тухайлбал манай улсын нийт гадаад өрийн дийлэнх хувийг гадаад валютаарх өр эзлэх ба түүний дотор урт хугацаат өр 95.2 хувь байна. 2020-2021 онуудад нийт гадаад өрийн 5.7 хувийн өсөлтөд үндэсний валютаарх өрийн бууралт мөн урт хугацаат гадаад валютаарх өрийн хэлбэлзэл нөлөө үзүүлж байна.

Улсын гадаад өрийг улсын болон хувийн секторын үзүүлэлтээр ангилж үзвэл улсын секторын хувьд Мазаалай бонд, Чингис бонд 2021-2022 онд, Гэрэгэ болон Хуралдай бондууд 2023 болон 2024 онуудад тус тус эргэн төлөгдөхөөр бөгөөд нийт санхүүжилтийн хэмжээ 2.9 сая америк доллар байна. Харин хувийн секторын хувьд Хөгжлийн банкны Самурай бонд, DM бондууд нь 2023 онд эргэн төлөгдөх бөгөөд санхүүжилтийн хувьд 30 тэрбум иен, 500 сая америк доллар, Энержи Ресурс ХХК-ийн Shine бонд нь 440 сая америк доллар бөгөөд 2024 онд эргэн төлөгдөхөөр байна. Pattillo нар (2002) шилжилтийн эдийн засагтай улс орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-нд эзлэх гадаад өрийн зохистой харьцааг 11-18 хувь байна гэж тогтоосон. Тэгвэл Амарсанаа нар (2013) уг харьцаа Монгол улстай адил зээлжилтийн нөхцөлтэй улс орнуудын хувьд ямар байгааг судлахад Blend зээлжилтийн категорит хамрагдах улс орнуудын ДНБ-д эзлэх гадаад өрийн харьцаа 1994-2012 онуудад 48 хувиас хэтрээгүй байсан нь тухайн орнууд цаашид гадаад өрийн хуримтлалаа

зохистойгоор нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтөө дэмжих боломжтой байгааг харуулсан. Харин манай улсын хувьд нийт гадаад өрийн үлдэгдэл тасралтгүй өссөн ч, засгийн газрын нийт өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2012 оны байдлаар 47 хувьтай байжээ.

Pattillo (2011) нар судалгааны ажлаараа гадаад өр болон өрийн бууралтын өсөлтөд үзүүлэх нөлөөллийн талаар аналитик хариулт өгөхийг зорьсон. Үр дүнд нь хөрөнгө оруулалтын түвшин хэт өндөр байх нь гадаад өрийн өсөлтийг бууруулахад төдийлөн ач холбогдолгүй бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээнээс илүү чанарт нөлөөлдөг болох нь тодорхойлогдсон. Түүнчлэн гадаад өрийг төлөхөд шаардлагатай татварын хэтийн төлөв нь тодорхойгүй байдлыг бий болгож, урт хугацааны төслүүдээс татгалзан, үр дүн багатай богино хугацааны төслүүдийг санхүүжүүлэхэд хүргэж байжээ. Adnan (2018) нар АНУ-ын нээлттэй компаниудын синдикат зээлийн зах зээлийг судалж үзэхэд татвараас зайлсхийх байдал нь зээлийн нөхцөлтэй эерэг холбоотой болохыг тогтоосон. Мөн хувийн болон улсын секторын өрийн санхүүжилт нь санхүүгийн хувьд уян хатан байснаар татвараас зайлсхийх байдалтай холбоотой эрсдлийг тодорхой хэмжээгээр бууруулдаг гэжээ. Sen нар (2018) Хятад улсын эдийн засаг дах бодит туршлагад үндэслэн татвараас зайлсхийх байдлын өрийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тооцож үзэхэд татвараас зайлсхийх эрсдэл нэмэгдсэнээр өрийн өртөг нэмэгдэх буюу шууд хамааралтай гэсэн үр дүн гарчээ.

Бид энэхүү судалгааны ажлыг хийж эхлүүлснээр дараах салбаруудад хувь нэмэр оруулна гэж үзсэн. Үүнд: бодлого боловсруулагчдад гадаад өр болон аж

ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийх байдлын хамаарлыг тогтооход судалгаанд суурилсан бодлого боловсруулах, салбарын судлаачдад татвараас зайлсхийх байдалд нөлөөлөх макро болон микро түвшний эдийн засгийн хүчин зүйлүүдтэй холбоотой судалгааг үргэлжлүүлэх, бизнесийн чиглэлээр мэргэшиж буй оюутнууд болон тус салбарын мэргэжилтнүүдэд татвараас зайлсхийх байдлын нөлөөллийг таниулан, цаашид гарах сөрөг үр дагаврыг бууруулах боломжийг тус тус бий болгох явдал юм. Бид дараагийн хэсэгт түүвэр сонголт, судалгааны загвар болон үр дүнг, гуравдугаар хэсэгт салбарын үр дүнг, дөрөвдүгээр хэсэгт дүгнэлт бичихээр бэлтгэлээ.

Судалгаа

Бид судалгаандаа олон аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулахыг зорьсон учраас Сангийн яамны цахим тайлангийн системд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийг түүвэрт сонгосон. 2013 оны байдлаар тус системд бүртгэлтэй 61,097 аж ахуйн нэгж байсан бөгөөд 2013-2016 оны турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байсан 15,571 аж ахуйн нэгж, байгууллагын 62,282 санхүүгийн тайлангийн мэдээллийг түүвэр болгон авсан. Мөн дэлхийн банкны дата сангаас 2013-2016 онуудын гадаад өрийн мэдээллийг авч ашигласан. Татвараас зайлсхийх байдалд улсын гадаад өр хэрхэн нөлөөлж буйг тодорхойлохын тулд хамааран хувьсагчаар татварын үр ашигтай хувь хэмжээг, үл хамааран хувьсагчаар гадаад өрийн таван үзүүлэлтийг, хяналтын хувьсагчдаар аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээ, хөрөнгийн өгөөж, үйл ажиллагааны мөнгөн урсгал болон капиталын өртгийг тус тус ашигласан бөгөөд судалгааны загвар

дараах байдалтай байна.

$$gaap_etr_{it} = \beta_0 + \beta_x * X_{it} + \beta_{abt} * DBT_t + \varepsilon_{it}$$

Үүнд: *gaap_etr* – татварын үр ашигтай хувь хэмжээ бөгөөд тайлант оны татварын зардлыг татварын өмнөх ашигт харьцуулж тооцно; *X* – хяналтын хувьсагчид (аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээ, хөрөнгийн өгөөж, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ болон капиталын өртөг); *DBT* – гадаад өр (нийт, улсын болон хувийн секторын, урт хугацаатай болон богино хугацаатай); *i* – тухайн аж ахуйн нэгжийг илэрхийлэх индекс; *t* – тухайн тайлант оныг илэрхийлэх

индекс.

Загварын хувьсагчдын статистик үзүүлэлтүүдийг тодорхойлсон үр дүнг Хүснэгт 1-т харууллаа. Уг үр дүнгээс нийт түүврийн хэмжээ 62,282 бөгөөд түүврийн дундаж, стандарт хазайлт, хамгийн бага болон хамгийн их утгуудыг харж болно. Стандарт хазайлт нь түүврийн утгууд дунджаасаа хэр хол зайд тархаж байгааг харуулдаг.

Корреляцийн шинжилгээ (Хүснэгт 2) нь хоёр тоон хүчин зүйл хэр их шугаман хамааралтай байна вэ гэдгийг

Хүснэгт 1. Тодорхойлох статистик

Хувьсагч	Түүврийн хэмжээ	Дундаж	Стандарт хазайлт	Минимум	Максимум
<i>gaap_etr</i>	62,282	0.0840	0.0989	0.0000	1.0000
<i>totexdbt</i>	62,282	1.9831	0.2817	1.6157	2.3961
<i>prvexdbt</i>	62,282	1.3863	0.1771	1.1498	1.6386
<i>pubexdbt</i>	62,282	0.3839	0.0686	0.3225	0.4990
<i>lngexdbt</i>	62,282	1.7701	0.2424	1.4722	2.1375
<i>shtexdbt</i>	62,282	0.2052	0.0449	0.1317	0.2522
<i>size</i>	62,282	10.9270	2.2884	-0.3567	21.3641
<i>roa</i>	62,282	-0.0192	9.4800	-2117.8600	262.7726
<i>capint</i>	62,282	0.3852	0.3305	-0.0066	16.3763
<i>cfot</i>	62,282	0.0169	9.1558	-2011.2900	429.5792

Хүснэгт 2. Корреляцийн матриц

	<i>gaap_etr</i>	<i>totexdbt</i>	<i>prvexdbt</i>	<i>pubexdbt</i>	<i>lngexdbt</i>	<i>shtexdbt</i>	<i>size</i>	<i>roa</i>	<i>capint</i>
<i>totexdbt</i>	-0.0030								
<i>prvexdbt</i>	-0.0037	0.9989 ***							
<i>pubexdbt</i>	0.0140 ***	0.9482 ***	0.9347 ***						
<i>lngexdbt</i>	0.0013	0.9980 ***	0.9949 ***	0.9657 ***					
<i>shtexdbt</i>	-0.0283 ***	0.9258 ***	0.9365 ***	0.7626 ***	0.8998 ***				
<i>size</i>	-0.0406 ***	0.0852 ***	0.0862 ***	0.0701 ***	0.0828 ***	0.0918 ***			
<i>roa</i>	0.0155 ***	-0.0044	-0.0046	-0.0052	-0.0048	-0.0017	0.0425 ***		
<i>capint</i>	-0.0415 ***	-0.0195 ***	-0.0191 ***	-0.0207 ***	-0.0198 ***	-0.0159 ***	0.0851 ***	0.0071 *	
<i>cfot</i>	0.0077 *	-0.0044	-0.0045	-0.0050	-0.0047	-0.0024	0.0330 ***	0.9129 ***	0.0059

харуулдаг статистик юм. Өөрөөр хэлбэл, хувьсагчууд эерэг хамааралтай байна гэдэг нь нэг хувьсагчийн утга өсөхөд нөгөө хувьсагчийн утга дагаад нэмэгдэх үзэгдэл, харин сөрөг хамааралтай байна гэдэг нь нэг хувьсагчийн утга өсөхөд нөгөө хувьсагчийн утга буурах явдал юм. Дээрх тооцооллоос харахад сул эерэг хамааралтай хувьсагчууд нь урт хугацаат гадаад өр болон татварын үр ашигт хувь хэмжээ (GAAP ETR)-ний хамаарал байна. Харин хүчтэй эерэг хамааралтай нь богино хугацаат гадаад өр болон нийт гадаад өр байна. Хүчтэй сөрөг хамааралтай хувьсагчууд нь нийт хөрөнгөд ногдох капиталын өртөг болон GAAP ETR байна. Хүснэгт 3-т судалгааны үндсэн үр дүнг түүвэр судалгааны ерөнхий хувьсагчийн хүрээнд болон түүврийн хэмжээ, түүнд тооцоолсон статистик үзүүлэлтийн хамтаар харууллаа. Эндээс харахад нийт, хувийн болон улсын секторын урт хугацаатай гадаад өр болон татварын үр ашигтай хувь хэмжээний хооронд эерэг хамааралтай, харин богино хугацаатай гадаад өр татварын үр ашигтай хувь хэмжээний хооронд сөрөг хамааралтай байна. Энэ нь нийт, хувийн болон улсын секторын, урт хугацаатай гадаад өрийн хэмжээ нэмэгдэхэд татвараас зайлсхийх

байдал буурдаг. Харин богино хугацаатай гадаад өр ихсэх тусам татвараас зайлсхийх байдал нэмэгддэг болохыг харуулж байна. Эндээс богино хугацаатай гадаад өр аж ахуйн нэгж, байгууллагуудад дарамт болдог гэсэн дүгнэж болохоор байгаа юм.

Хувийн секторын гадаад өрийн хувьд 0.36 хувийн сөрөг хамааралтай байгаа нь гадаад өрийн хэмжээ ихсэхэд татвараас зайлсхийх байдал тодорхой хэмжээгээр буурахыг харуулж байгаа юм. Энэ нь хувийн аж ахуйн нэгжүүд эрсдэлээ үүрэн, гадаадаас зээл авч өөрсдийгөө санхүүжүүлж үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байгаа нь ашиг, орлогыг нэмэгдүүлж, улмаар орлогын албан татвараа хуулийн дагуу төлөх нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Дараагийн хувьсагч болох улсын секторын гадаад өр нь татвараас зайлсхийх байдалтай сөрөг хамааралтай байгаа нь дараах шалтгаантай нийцэж байгаа юм. Тухайн засаглалын үед зам талбай засах, шинээр тавих зэрэг нийтийн бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Чингис, Самурай зэрэг бонд гаргаж гаднаас их хэмжээний санхүүжилт татсан. Энэ нь улсын секторын аж ахуйн нэгжийн санхүүгийн чадавхид эерэг нөлөө үзүүлж, татварын үр ашигт хувь хэмжээг ихэсгэн

Хүснэгт 3. Үндсэн үр дүн

Хувьсагч	<i>totexdbt</i>	<i>prvexdbt</i>	<i>pubexdbt</i>	<i>lngexdbt</i>	<i>shtexdbt</i>
<i>size</i>	-0.0018**	-0.0017**	-0.0027***	-0.0021***	0.0005
<i>roa</i>	0.0204***	0.0203***	0.0216***	0.0207***	0.0187***
<i>capint</i>	-0.0111***	-0.0111***	-0.0106***	-0.0110***	-0.0114***
<i>cfot</i>	-0.0045***	-0.0045***	-0.0046***	-0.0045***	-0.0044***
DBT	0.0025*	0.0036*	0.0374***	0.0050***	-0.0569***
Сул гишүүн	0.1015***	0.1010***	0.1023***	0.1011***	0.0931***
Түүврийн тоо	62,282	62,282	62,282	62,282	62,282
ААН тоо	15,571	15,571	15,571	15,571	15,571
F статистик	48.6303 (0.0000)	48.5442 (0.0000)	57.2228 (0.0000)	49.9997 (0.0000)	56.7206 (0.0000)
R ²	0.0052	0.0052	0.0061	0.0053	0.0060

татвараас зайлсхийх байдал буурсан байна. Тухайлбал, нийтийн гудамж талбай, зам засах, байгуулах ажлыг аж ахуйн нэгжүүдийн дундаас сонгон шалгаруулж санхүүжилт олгодог байна. Энэ нь тухайн аж ахуйн нэгжийг ашиг, орлоготой байлгаж буй явдал бөгөөд татвараа төлөх чадвар нь ихэсч, татвараас зайлсхийх байдлыг бууруулж байна гэж үзэж болно. Мөн нийтийн гадаад өр нь хувийн болон урт хугацаат өрийн үзүүлэлтээс илүү хувиар татварын үр ашигт хувь хэмжээтэй сөрөг хамааралтай байгааг үр дүнгээс мэдэж болохуйц байна.

Урт хугацаат гадаад өр болох нэг жилээс дээш хугацаанд төлөх ёстой өр нь татварын үр ашигт хэмжээтэй 0.50 хувийн эерэг хамааралтай байгаа нь татвараас зайлсхийх байдал буурахад тодорхой хэмжээний нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Харин богино хугацаат гадаад өр буюу нэг жилийн дотор төлөгдөх ёстой гадаад өр нь татвараас зайлсхийх байдалтай 5.69 хувийн эерэг хамааралтай байгаа ба энэ нь аж ахуйн нэгжүүдэд богино хугацааны өр нь дарамт болж болзошгүйг харуулж байгаа юм. Үүний үр дүнд татварын үр ашигт хувь хэмжээ буурч татвараас зайлсхийх байдал өссөн үзүүлэлттэй байна.

Салбарын шинжилгээ

Мөн бид тооцооллын хүрээнд салбаруудын татвараас зайлсхийх байдлыг шинжилж үзсэн. Үндэсний статистикийн хорооноос манай улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагааны чиглэлээс хамааруулан 21 салбарт хуваан авч үздэг. Бидний судалгааны түүвэрт сонгогдсон аж ахуйн нэгжүүд эдгээрээс 19 салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд байсан ба тооцооллыг хялбарчлах үүднээс тэдгээрийг нэгтгэн хөдөө аж ахуй, уул уурхай, үйлдвэрлэл, үйлчилгээ болгон салбар тус бүрийн татвараас зайлсхийх байдалд улсын гадаад өр хэрхэн нөлөөлж байгааг тооцоолсон.

Салбар тус бүрийн үр дүн нь түүврийн хэмжээ болон үйл ажиллагаа эрхлэлтийн онцлогоос шалтгаалан өөр өөр болохыг хүснэгтүүдээс харж болохоор байна. Тухайлбал, Хүснэгт 4-т буй хөдөө аж ахуйн салбарын шинжилгээнд 576 аж ахуйн нэгжийн 2,304 санхүүгийн тайлан түүврийн хүрээнд сонгогдсон ба татвараас зайлсхийх байдалд регрессийн хувьсагчдаас нийтийн гадаад өр нь хамгийн өндөр буюу 8.61 хувийн сөрөг хамааралтай байна. Хөдөө аж ахуйн салбарыг дэмжсэн санхүүжилт ихсэх нь

Хүснэгт 4. Салбарын үр дүн – Хөдөө аж ахуй

Хувьсагч	<i>totexdbt</i>	<i>prvexdbt</i>	<i>pubexdbt</i>	<i>lngexdbt</i>	<i>shtexdbt</i>
<i>size</i>	-0.0035	-0.0033	-0.0042	-0.0038	-0.0006
<i>roa</i>	0.0402***	0.0402***	0.0413***	0.0407***	0.0373***
<i>capint</i>	0.0059	0.0059	0.0065	0.0060	0.0058
<i>cfot</i>	-0.0164*	-0.0164*	-0.0164*	-0.0164*	-0.0159*
DBT	0.0144*	0.0218*	0.0861***	0.0187**	0.0161
Сул гишүүн	0.0809	0.0778	0.0845*	0.0797	0.0760
Түүврийн тоо	2,304	2,304	2,304	2,304	2,304
ААН тоо	576	576	576	576	576
F статистик	3.4028 (0.0046)	3.3336 (0.0053)	4.2601 (0.0007)	3.5813 (0.0032)	2.7290 (0.0183)
R ²	0.0098	0.0096	0.0122	0.0103	0.0079

тус салбарын аж ахуйн нэгжийн татварын үр ашигт хувь хэмжээг нэмэгдүүлэн улмаар татвараас зайлсхийх байдлыг бууруулж байдаг.

Хүснэгт 5-т уул уурхайн салбарын шинжилгээний үр дүнг харуулсан ба тухайн үр дүнгээс богино хугацааны гадаад өрийн хэмжээ ихсэх нь татвараас зайлсхийх байдалд 12.6 хувийн эерэг хамааралтай болох нь харагдаж байна. Харин нийтийн гадаад өр нь 2.65 хувийн сөрөг хамааралтай байна. Эдгээрээс уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдэд богино хугацааны гадаад өрөөс илүүтэйгээр нийтийн гадаад өрийн санхүүжилт нь татвараас зайлсхийх байдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна.

Хүснэгт 6-д харуулсан үйлдвэрлэлийн

салбарын шинжилгээний үр дүнд 2,650 аж ахуйн нэгжийн 10,600 санхүүгийн тайланг түүврийн хэмжээнд хамруулсан ба тухайн салбарын татвараас зайлсхийж буй байдалд богино хугацааны гадаад өрийн санхүүжилт нь 11.6 хувь буюу хамгийн их хамааралтай байна. Тодруулбал, үйл ажиллагааны циклийн онцлогоос хамааран санхүүжилтийн хэлбэр богино байх нь татварын үр ашигт хувь хэмжээг бууруулж, татвараас зайлсхийх байдлыг нэмэгдүүлдэг байна.

Үйлчилгээний салбарын шинжилгээний үр дүнгийн тооцооллыг Хүснэгт 7-д харуулсан ба энэхүү салбарын аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийх байдалд нийтийн гадаад өр нь 3.44 хувийн сөрөг хамааралтай байна. Харин богино

Хүснэгт 5. Салбарын үр дүн – Уул уурхай

Хувьсагч	<i>totexdbt</i>	<i>prvexdbt</i>	<i>pubexdbt</i>	<i>lngexdbt</i>	<i>shtexdbt</i>
<i>size</i>	0.0070	0.0075	0.0042	0.0064	0.0106
<i>roa</i>	-0.0092	-0.0097	-0.0059	-0.0086	-0.0108
<i>capint</i>	-0.0766*	-0.0769*	-0.0746*	-0.0763*	-0.0783*
<i>cfot</i>	0.0170	0.0173	0.0155	0.0167	0.0189
DBT	-0.0066	-0.0138	0.0265	-0.0050	-0.1266
Сул гишүүн	0.0321	0.0310	0.0466	0.0357	-0.0041
Түүврийн тоо	496	496	496	496	496
ААН тоо	124	124	124	124	124
F статистик	0.9238 (0.4660)	0.9386 (0.4553)	0.9239 (0.4660)	0.9114 (0.4742)	1.0966 (0.3606)
R ²	0.0124	0.0126	0.0124	0.0123	0.0147

Хүснэгт 6. Салбарын үр дүн – Үйлдвэрлэл

Хувьсагч	<i>totexdbt</i>	<i>prvexdbt</i>	<i>pubexdbt</i>	<i>lngexdbt</i>	<i>shtexdbt</i>
<i>size</i>	-0.0010	-0.0010	-0.0024	-0.0015	0.0019
<i>roa</i>	0.0108***	0.0108***	0.0125***	0.0113***	0.0093***
<i>capint</i>	-0.0076*	-0.0076*	-0.0076*	0.0076*	-0.0072
<i>cfot</i>	-0.0013	-0.0013	-0.0015	-0.0013	-0.0013
DBT	-0.0033	-0.0055	-0.0242*	-0.0090	-0.1165***
Сул гишүүн	0.1022***	0.1029***	0.1021***	0.1023***	0.0847***
Түүврийн тоо	10,600	10,600	10,600	10,600	10,600
ААН тоо	2,650	2,650	2,650	2,650	2,650
F статистик	3.5234 (0.0036)	3.5382 (0.0034)	3.9384 (0.0015)	3.3528 (0.0049)	8.8643 (0.0000)
R ²	0.0022	0.0022	0.0025	0.0021	0.0055

Хүснэгт 7. Салбарын үр дүн – Үйлчилгээ

Хувьсагч	<i>totexdbt</i>	<i>prvexdbt</i>	<i>pubexdbt</i>	<i>lngexdbt</i>	<i>shtexdbt</i>
<i>size</i>	-0.0012	-0.0012	-0.0022***	-0.0016*	0.0009
<i>roa</i>	0.0232***	0.0232***	0.0243***	0.0235***	0.0217***
<i>capint</i>	-0.0133***	-0.0133***	-0.0125***	-0.0131***	-0.0141***
<i>cfot</i>	-0.0048***	-0.0048***	-0.0048***	-0.0048***	-0.0047***
DBT	0.0022	0.0033	0.0344***	0.0046**	-0.0522***
Сул гишүүн	0.0970***	0.0966***	0.0978***	0.0966***	0.0900***
Түүврийн тоо	40,898	40,898	40,898	40,898	40,898
ААН тоо	10,200	10,200	10,200	10,200	10,200
F статистик	46.7233 (0.0000)	46.6688 (0.0000)	51.9529 (0.0000)	47.5467 (0.0000)	51.6523 (0.0000)
R ²	0.0076	0.0076	0.0084	0.0077	0.0084

хугацааны гадаад өрийн хувьд 5.22 хувийн эерэг хамааралтай буюу эдгээр хоёр хувьсагчийн үр дүн нь урвуу болохыг харж болохоор байна.

Дүгнэлт

Татварын бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, татварын боловсролыг дээшлүүлэх арга зам, татварын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох гэх мэт хүрээг хамарсан судалгааны ажлууд манай улсын хувьд харьцангуй их хийгдсэн ч татвараас зайлсхийж буй байдалд улсын гадаад өр хэрхэн нөлөөлж буйг тооцсон ажил хараахан хийгдээгүй байна. Тиймээс бид татварын үр ашигтай хувь хэмжээг үнэлэх загвар ашиглан манай улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийж буй байдалд улсын гадаад өр хэрхэн нөлөөлж буй байдлыг судлахыг зорьсон.

Судалгааны түүвэрт 2013-2016 онуудад тасралтгүй үйл ажиллагаа явуулж санхүүгийн тайлангаа тогтмол илгээсэн 15,571 аж ахуйн нэгжийн дөрвөн жилийн хугацаан дахь 62,282 санхүүгийн тайлангийн мэдээллийг сонгон авсан. Эдгээр аж ахуйн нэгжүүдэд улсын нийт гадаад өр, улсын болон хувийн секторын гадаад өр, урт хугацааны болон богино хугацааны гадаад өр хэрхэн нөлөөлж

байгааг регрессийн шинжилгээгээр тооцож үзэхэд татварын үр ашигт хувь хэмжээ болон нийт гадаад өр нь 0.25 хувийн эерэг хамааралтай, хувийн секторын гадаад өр нь 0.36 хувийн эерэг хамааралтай, нийтийн болон урт хугацааны гадаад өрүүд нь тус тус 3.74 хувь, 0.50 хувийн эерэг хамааралтай байна. Татварын үр ашигт хувь хэмжээ нь татвараас зайлсхийх байдалтай сөрөг хамааралтай бөгөөд эдгээр гадаад өрүүд нь татвараас зайлсхийх байдлыг бууруулж байна гэж үзсэн. Харин богино хугацаат гадаад өр нь татварын үр ашигт хувь хэмжээтэй 5.69 хувийн сөрөг хамааралтай байгаа нь татвараас зайлсхийх байдал ихсэхэд нөлөөлж байна. Энэ нь аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн байдалд богино хугацаатай өр төлбөр дарамт болдог гэсэн үг юм. Тиймээс богино хугацаат гадаад өрийг бууруулах арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзсэн. Нэгтгэн дүгнэвэл, улсын гадаад өр хэт их байх нь эдийн засагт сайн зүйл биш хэдий ч үр ашигтай зарцуулбал эдийн засагт эерэг нөлөөтэй байх боломжтой юм. Нөгөө талаас гадаад өрийн зохистой хэмжээг бодлогын түвшинд тодорхойлох нь татвараас зайлсхийх байдлыг бууруулахад эерэг нөлөөтэй байж болохыг судлаачид онцолж байна.

Ашигласан материал

- Armstrong, C. S., Blouin, J. L., & Larcker, D. F. (2012). The incentives for tax planning. *Journal of Accounting and Economics*, 53(1-2), 391-411. <https://doi.org/10.1016/j.jacceco.2011.04.001>
- Desai, M. A. & Dharmapala, D. (2009). Corporate tax avoidance and firm value. *The Review of Economics and Statistics*, 91(3), 537-546.
- Dyreng, S. D., Hanlon, M., & Maydew, E. L. (2008). Long-run corporate tax avoidance. *The Accounting Review*, 83(1), 61-82.
- Halioui, K., Neifar, S., & Abdelaziz, F. B. (2016). Corporate governance, CEO compensation and tax aggressiveness: Evidence from American firms listed on the NASDAQ 100. *Review of Accounting and Finance*, 15(4), 445-462. <https://doi.org/10.1108/RAF-01-2015-0018>
- Hasan, I., Hoi, C. K., Wu, Q., & Zhang, H. (2014). Beauty is in the eye of the beholder: The effect of corporate tax avoidance on the cost of bank loans. *Journal of Financial Economics*, 113(1), 109-130. <https://doi.org/10.1016/j.jfineco.2014.03.004>
- Isin, A. A. (2018). Tax avoidance and cost of debt: The case for loan-specific risk mitigation and public debt financing. *Journal of Corporate Finance*, 49(April), 344-378. <https://doi.org/10.1016/j.jcorpfin.2018.01.003>
- Mocanu, M., Constantin, S-B., & Răileanu, V. (2021). Determinants of tax avoidance – evidence on profit tax-paying companies in Romania. *Economic Research*, 34, 2013-2033. <https://doi.org/10.1080/1331677X.2020.1860794>
- Pattillo, C., Poirson, H., & Ricci, L. (2002). External debt and growth. *IMF Working Paper*, WP/02/69.
- Richardson, G. & Lanis, R. (2007). Determinants of the variability in corporate effective tax rates and tax reform: Evidence from Australia. *Journal of Accounting and Public Policy*, 26(6), 689-704. <https://doi.org/10.1016/j.jaccpubpol.2007.10.003>
- Richardson, G., Taylor, G., & Lanis, R. (2015). The impact of financial distress on corporate tax avoidance spanning the global financial crisis: Evidence from Australia. *Economic Modelling*, 44, 44-53.
- Cen, W., Tong, N., & Sun, Y. (2017). Tax avoidance and cost of debt: Evidence from a natural experiment in China. *Accounting and Finance*, 57(5), 1517-1556. <https://doi.org/10.1111/acfi.12328>
- Цэцэгдэлгэр, Э. & Алтан-Эрдэнэ, Б. (2021). Аж ахуйн нэгж, байгууллагуудын татвараас зайлсхийх байдлыг илрүүлэх нь. *Нягтлан бодох бүртгэлийн онол, практик*, 5(1), 81-91.